

**АЙМГИЙН ИТХ, ИТХТ-ИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ**

2023 оны 12 дугаар сарын 25

Залаа

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ
1	2	3	4	5	6	7
Аймгийн ИТХ-ын тогтоол						
1	1	Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр батлах тухай 2021-12-14 Дугаар 2021_131	1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, байгууллага хоорондын уялдаа холбоогүй хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай	Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилласан. Сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн "Хог хаягдлыг цэвэрлэх ажлыг эрчимжүүлэх тухай", Эхэнхавцгай багийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн "Хог хаягдлын их цэвэрлэгээг зохион байгуулах тухай" захирамжуудын хүрээнд нийтийн их цэвэрлэгээ 5 удаа зохион байгуулагдаж нийт 250 иргэн хамрагдан 25 тн хог хаягдал хогийн цэгт хүргэж ажилласан байна. Энэ оны онцлог ажил нь хогийн цэгийг дарж булшлах, шинээр хогийн цэг байгуулах ажил хийгдсэн бөгөөд "Эрдэнэ Монгол" ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд санхүүжилтийг шийдвэрлэн "Талын нөмөр" ХХК гэрээгээр гүйцэтгэсэн. Сургалт сурталчилгаа, бүтээн байгуулалтын онцлог ажлуудыг хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлж ажилласан бөгөөд цаашид 2024 онд хэрэгжүүлэхээр Хог хаягдлын мастер төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлууллаа.	100%	100%
2	2	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх сангийн дүрэм баталж, зөвлөл байгуулах тухай 2021-12-22	1. Сангийн дүрмийг олон нийтэд сурталчилж, ажиллах нөхцөлийг бүрдүүлж, хамтран ажиллахыг аймаг, сумдын Засаг дарга нартай даалгасугай	Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар 4 багийн Иргэдийн нийтийн хурлаар 300-аад малчдад сурталчилж, сан байгуулах тухай хэлэлцүүлэхэд хуралд оролцогчдын 80-аас дээш хувь нь "Манай суманд мал хулгайлах гэмт хэрэг гардаггүй, малчдын хариулга маллагаа сайн" байдаг учраас сан байгуулах шаардлагатай гэж	100%	100%

1	2	3	4	5	6	7
		Дугаар 2021_144		шийдвэрлэсэн. Жилийн эцсийн байдлаар мал хулгайлах гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.		
3	3	Эдийн засгийг сэргээн хөгжүүлж, тогтвортой хөгжлийг бий болгох "Баялаг бүтээгч-Баянхонгор" хөтөлбөр батлах тухай 2021-12-24 Дугаар 2021_7/30	1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, байгууллага хоорондын уялдаа холбоог хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.	Аймгийн хөгжлийн төлөвлөгөөнөөс сумд хамааралтай заалтыг тусган сумын 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг ИТХ-ын 22 гишүүнийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн 13 дугаар хуралдааны үеэр хэлэлцүүлж, нийт 37 заалтаас Үр дүнтэй: 100 хувь хэрэгжсэн 28 заалт, Тодорхой үр дүнд хүрсэн 90 хувьтай-3 заалт, 70 хувьтай-2 заалт, Эрчимжүүлэх шаардлагатай 50 хувьтай - 1 заалт, 30 хувьтай - 1 заалт, Үр дүнгүй 2 заалт байсан. 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлт 89 хувьтай гэж хуралдаанаар баталсан. Эрчимжүүлэх шаардлагатай болон үр дүнгүй хэрэгжсэн 2 заалтыг 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусган төлөвлөлөө.	100%	100%
4	4	Ковидын дараах сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөө батлах тухай 2022-02-25 Дугаар 2022_8/10	1. Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажилсугай.	Хоцрогдол арилгах төлөвлөгөө"-г бага, дунд ангийн заах аргын нэгдлээр тус тус хэлэлцүүлж Бага анги, дунд анги тус бүрээр боловсруулж батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хичээлийн жилийн 2, 3 дугаар улиралд тус тус гаргаж багш нарын зөвлөлийн хурал, дунд ангийн эцэг эхийн хурлаар тус тус нэг удаа хэлэлцүүлсэн.	70%	70%
5	5	Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай 2022-12-02 Дугаар 2022_12/54	1. Хөгжлийн төлөвлөгөөг олон нийтэд мэдээлж, салбар дундын хамтын ажиллагааг хөгжүүлж, зорилт арга хэмжээ бүрийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-дүүрэг болгосугай.	Аймгийн хөгжлийн төлөвлөгөөнөөс сумд хамааралтай заалтыг тусган сумын 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг ИТХ-ын 22 гишүүнийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдөр Иргэдийн төлөөлөгчдийн 13 дугаар хуралдааны үеэр хэлэлцүүлж, нийт 37 заалтаас Үр дүнтэй: 100 хувь хэрэгжсэн 28 заалт, Тодорхой үр дүнд хүрсэн 90 хувьтай-3 заалт, 70 хувьтай-2 заалт, Эрчимжүүлэх шаардлагатай 50 хувьтай - 1 заалт, 30 хувьтай - 1 заалт,	100%	100%

1	2	3	4	5	6	7
				Үр дүнгүй 2 заалт байсан. 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлт 89 хувьтай гэж хуралдаанаар баталсан. Хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг shinejinst.bkh.gov.mn сайт дээр байршуулсан.		
Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол						
6	6	“Ухаалаг Баянхонгор” аймгийн дэд хөтөлбөр батлах тухай 2019-01-31 Дугаар 2021_02	1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, шаардлагатай төсөв, зохион байгуулах ажлыг аймгийн жил бүрийн эдийн засаг дүнгийн хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусган батлуулан, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.	Хяналт шинжилгээ үнэлгээ https://bayankhongor.igovernment.mn/ бодлогын баримт бичгийн биелэлт, хэрэгжилтүүдийг цахимаар тайлагнаж байна. Сумын хэмжээнд нийт 6 төрийн байгууллага төрийн үйлчилгээний үйл ажиллагааг явуулж байна. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч DOCX TOKEN -д албан хаагчдын Э-мэйл хаяг, утасны дугаарыг холбож баталгаажуулсан. https://eoffice.bayanhongor.gov.mn/login программд 4 сард 5 албан хаагчид хандах эрх аван холбогдож захирамжийн 20 төслийг хянуулан гаргасан. Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем болох ERP-д төрийн 5 байгууллага бүрэн холбогдон өдөр тутмын албан хэрэгцээндээ хэрэглэж хэвшсэн бөгөөд ЗДТГ-ын нийт 30 албан хаагчид бүртгэгдсэн. Албан хаагчид цаг бүртгэлээ мөн ERP-ээр бүртгүүлж хэвшиж байна. Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийг албан бичиг солилцооны дундын системтэй холбон байгууллагын ирсэн бичиг болон явсан бичгийг цахимаар явуулж бүрэн хэвшээд байна. Ер системээр нийт 552 бичиг хүлээн авч хариу шийдвэрлэсэн бичиг 261, хэрэгжих шатандаа 247, шилжүүлсэн 544, байгууллагаас хариутай 219 бичиг илгээсэн. Төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд shinejinst.gov.mn веб сайт, Шинэжинст ЗДТГ фэйж (410like, 542followers), Shinejinst shinejinst (1000friend) фэйсбүүк хаяг нээн тус бүр 3 сошиал медиагаар иргэдэд мэдээлэл хүргэж ажиллаж байна. Жилийн хугацаанд онцлох үйл явдлын 18 зурган мэдээ, видео бичлэг 2, постер 7, зарын чанартай 20 мэдээг нийтэлж ажилласан.	100%	100%

1	2	3	4	5	6	7
				Мөн жилийн эцсийн байдлаар нийт 10 төрлийн үйлчилгээ, 210 лавлагааг операторын эрхээр, давхардсан тоогоор 125 хүнд имонголиа нээж, нууц үг солих, бүртгэлтэй утасны дугаар солих үйлчилгээ үзүүлж, ажилласан байна.		
7	7	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх” аймгийн дэд хөтөлбөр батлах тухай 2020-08-26 Дугаар 2021_71	1. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, ажлуудыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гарган аймгийн жил бүрийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусган батлуулан, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулан, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Мөнхсайхан/-д даалгасугай.	Сумын хэмжээнд нийгмийн асуудлаар хүний хөгжлийн төлөвлөгөөнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр оруулж, хийх ажлын санхүүжилтийг батлуулж, төлөвлөгөөний дагуу тодорхой ажлуудыг хэрэгжүүлж ажилласан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр, мөн аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын газраас гэр бүлийн чиглэлээр зохион байгуулах ажилд 300,0 төгрөгийн санхүүжилтийг олгож ажлын дэмжлэг болгосон.	70%	70%
8	8	“Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III” аймгийн дэд хөтөлбөр батлах тухай 2020-09-14 Дугаар 2021_90	1. Хоршоодын хамрах хүрээг өргөжүүлэн хөгжүүлэх, хөтөлбөрийн санхүүжилтийг орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд тусгаж, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулан үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны “Баянхонгор аймгийн Шинэжинст сумын 2023 оны төсөв батлах тухай” 77 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар “Хоршоог хөгжүүлэх сан”-гаас 2023 онд 98,603,100 төгрөгийн зээл олгохоор тусгаж шийдвэрлүүлсэн. Хоршоо хөгжүүлэх сангаас 2023 оны 8 дугаар сард “Цармын цагаан сувд” хоршооны Залаажинст үүлдрийн цагаан ямааны цөм сүрэг бүрдүүлэх зорилготой “Залаагийн сувд” төсөлд 40 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олголоо. 2022 онд “Залаа шинэ эргэлт”, “Залаажинст торгон сүрэг” зэрэг 2 хоршоонд Хоршоо хөгжүүлэх сангийн тус бүр 50, 50 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамруулсан.	100%	100%

1	2	3	4	5	6	7
			дарга /Д.Мөнхсайхан/-д даалгасугай.			
9	9	“Хуримтлалтай хонгорчууд” хөтөлбөр батлах тухай 2020-11-15 Дугаар 2021_59	1. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, ажлуудыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гарган аймгийн жил бүрийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусган батлуулан, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр аймгийн иргэдийн Төлөөлгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулан, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Мөнхсайхан/-д даалгасугай.	2024 онд төлөвлөж байна	0%	0%

ХЯНАСАН
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
 ГАЗРЫН ДАРГА *Д.Батхуяг* Д.БАТХУЯГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН
 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
 МЭРГЭЖИЛТЭН *Т.Батчимэг* Т.БАТЧИМЭГ

АЙМГИЙН ИТХ, ИТХТ-ИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО
(Өөрийн үнэлгээ)

2023 оны 12 дугаар сарын 25

Залаа

АЙМГИЙН ИТХ, ИТХТ-ИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО			
Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо 9			
Үүнээс	Үр дүнтэй	100%	6
	Тодорхой үр дүнд хүрсэн	90%	-
		70%	2
	Эрчимжүүлэх шаардлагатай	50%	
		30%	
Үр дүнгүй	0%	1	
Аймгийн итх, итхт-ийн 2023 оны жилийн эцсийн тогтоолын хэрэгжилтийн товчоо 82,2 хувьтай байна.			

_____ оОо _____

АЙМГИЙН ИТХ, ИТХТ-ИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО
(Дээд шатны байгууллагын үнэлгээ)

2023 оны 12 дугаар сарын 25

Залаа

АЙМГИЙН ИТХ, ИТХТ-ИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО			
Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо 9			
Үүнээс	Үр дүнтэй	100%	6
	Тодорхой үр дүнд хүрсэн	90%	-
		70%	2
	Эрчимжүүлэх шаардлагатай	50%	-
		30%	-
Үр дүнгүй	0%	1	
Аймгийн итх, итхт-ийн 2023 оны жилийн эцсийн тогтоолын хэрэгжилтийн товчоо 82,2 хувьтай байна.			

оОо